

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Хянан шалгах түр хороо
байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь хэсгийг үндэслэн хүүхэд хамгааллын чиглэлээр иргэд, олон нийтийн зүгээс тавьж буй асуудлыг ил тод, нээлттэй хэлэлцэх, хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, хуулийн хэрэгжилтийг бодитой дүгнэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Хүүхэд хамгааллын тогтолцооны үр нөлөө, хууль тогтоомжийн хэрэгжилт болон салбар хоорондын уялдаа”-г хянан шалгахгаар тогтоосугай.

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай:

1/Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын дагуу хүүхэд хамгааллын тогтолцооны төлөвшил үнэлдэг олон улсын аргачлалаар иж бүрэн үнэлгээ хийх;

2/Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанар, санхүүжилтийн бодит байдлыг шинжлэхдээ хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт, хүний нөөцийн чадавх нь зөвхөн төсвийн хуваарилалт бус, өрхийн эдийн засгийн чадамжийг дэмжих замаар хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон улсын жишигт нийцэж буй эсэхэд бодит дүн шинжилгээ хийх;

3/Хамтарсан багийн үйл ажиллагааны үр нөлөө, хариуцлагын механизмыг хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж чадаж буй эсэхээр шалгах;

4/Төрийн байгууллагуудын уялдаа холбоо, чиг үүргийн давхардал, хийдлийг тогтоох, салбар хоорондын мэдээлэл солилцооны загвар нэвтэрсэн эсэхийг шалгах;

5/Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчлийн бодит нөхцөл байдлыг INSPIRE-ийн долоон бүлэг үзүүлэлтээр нарийвчлан оношилж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөөг үнэлэх;

6/Хуулийн хэрэгжилтэд тулгарч буй хүндрэл, эрх зүйн хийдэл, давхардал, зохицуулалтгүй байдал, тогтолцооны сул талыг илрүүлж хянан шалгах түр хорооны нэгдсэн санал, дүгнэлт гаргах

3.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Олонхийг төлөөлөн:

..... Улсын Их Хурлын гишүүн
..... Улсын Их Хурлын гишүүн
..... Улсын Их Хурлын гишүүн
..... Улсын Их Хурлын гишүүн

Цөөнхийг төлөөлөн:

..... Улсын Их Хурлын гишүүн
..... Улсын Их Хурлын гишүүн
..... Улсын Их Хурлын гишүүн
..... Улсын Их Хурлын гишүүн

4.Тусгай шалгалтыг хэрэгжүүлж, тайлан, санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулахыг Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2026 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг